



Алдагдсан ХОНЬ

Сайн хоньчин зуун хоньтой байв. Нэг нь алдагджээ.



Тэрээр 99-ийг нь орхиод, алдагдсан нэг хонины араас явав.

Хонио олоод, Тэр ихэд баярлажээ. Тэр баяртайгаар хонио мөрөндөө тэгнэн, гэртээ харилаа.



Тэгээд найз нөхөд, хөршүүдээ дуудаж, “Би алдагдсан хонио олсон тул надтай хамт баярлагтун” (Лук 15:6) гэж тэр хэлэв.



Бидний сайн Хоньчин хэн бэ?

Бидний Сайн Хоньчин хувиршгүй бөгөөд энэ дэлхий дээр байхдаа нүгэл болон нүгэлтнүүдийн талаар ямар бодолтой байсан, одоо ч тэр хэвээрээ байгаа. . . . Тэр бидэнд маш их хайртай болохоор бидэнд наманчлах, цэвэрших, тэгснээр Түүн дээр болон Тэнгэрлэг Эцэг дээрээ очих замыг бэлтгэж өгсөн юм. . . .

“ . . . Есүс Христ бол бидний Сайн Хоньчин бөгөөд биднийг хайрлаж, бидэнд санаа тавьдаг гэдгийг би гэрчилж байна. Тэр биднийг мэддэг мөн Өөрийн хоньдын төлөө амьдралаа өгсөн.”

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын охлагч Дэйл Г.Рэнланд (2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган).

ЭНЭ ЮУ ГЭСЭН УТГАТАЙ ВЭ?

Гэм нүгэлтэй хүмүүс бол алдагдсан хоньтой адил. Гэм нүгэлт хүнийг наманчлахад тэнгэрт баярладаг хэмээн Аврагч заасан (Лук 15:7-г үзнэ үү).